



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/92/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот
2023.02.17

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

“Глобаль капитал аудит” ХХК-ын захирал Д.Энхтуяа
Утас: 89499922 Цахим хаяг: enkhtuyad@gmail.com
Аудитор Д.Цэцэгмаа
Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.com

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5.Аудитын илрүүлэлт	20
5.2. Төлбөрийн акт	21
5.3. Албан шаардлага	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement. bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/38

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэцогт сумын Цэцэрлэг нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д Орой, эчнээ, албан бус хэлбэрээр иргэдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ гэсний дагуу Цэцэрлэгийн хувьсах зардлаар тооцсон зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативыг шинэчлэн баталснаар БШУ-ны сайдын 2022.05.12-ны А/170 тушаалаар "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал"-ыг баталсан байна.

Дээрхи өөрчлөлттэй холбоотойгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайланг санхүүжилтийн эх үүсвэрээс хамааран улсын төсвийн, орон нутгийн төсвийн гэж тайлагнан Сангийн яамны e-balance.mof.gov.mn системд шивж оруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>69,928,159.58</u>	<u>136,065,261.45</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	61,977,481.87
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	61,977,481.87
3121	Төгрөг	00.00	61,977,481.87
31211	Төрийн сангийн харилцах	00.00	61,977,481.87
33	АВЛАГА	560,450.28	560,450.28
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	520,550.97	520,550.97
335	Бусад авлага	39,899.31	39,899.31
3351	Байгууллагаас авах авлага	39,899.31	39,899.31
34	УРЬДЧИЛГАА	100,000.00	4,070,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	100,000.00	4,070,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	100,000.00	4,070,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	69,267,709.30	69,457,329.30
351	Түүхий эд материал	2,118,400.00	619,100.00
35130	Эм боох материал	2,118,400.00	619,100.00
354	Хангамжийн материал	67,149,309.30	68,838,229.30
35410	Бичиг хэргийн материал	914,000.00	1,052,000.00
35420	Аж ахуйн материал	61,009,259.30	64,911,189.30
35460	Хүнсний материал	4,201,050.00	2,275,040.00
35470	Бусад хангамжийн материал	1,025,000.00	600,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>911,675,929.55</u>	<u>1,041,331,826.17</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	911,675,929.55	1,041,331,826.17
392	Биет хөрөнгө	904,195,929.55	1,033,851,826.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	969,395,186.90	1,111,848,638.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	-98,331,983.69	-114,482,551.37
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,608,650.00	31,156,250.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-10,323,834.80	-12,658,848.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,280,200.00	37,690,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,341,288.86	-21,611,263.16
39217	Ном	1,909,000.00	1,909,000.00
393	Биет бус хөрөнгө	7,480,000.00	7,480,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,480,000.00	7,480,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>981,604,089.13</u>	<u>1,177,397,087.62</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,259,147.00</u>	<u>540,350.00</u>

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,259,147.00	540,350.00
413	Өглөг	1,259,147.00	540,350.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,259,147.00	540,350.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	980,344,942.13	1,176,856,737.62
51	Засгийн газрын хувь оролцоо	980,344,942.13	1,176,856,737.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	100,436,916.11	100,436,916.11
51101	Өмч: - төрийн	100,436,916.11	100,436,916.11
512	Хуримтлагдсан үр дүн	-16,894,732.40	179,617,063.09
51210	Өмнөх үеийн үр дүн	-16,894,732.40	-16,894,732.40
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	196,511,795.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	896,802,758.42	896,802,758.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	981,604,089.13	1,177,397,087.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	291,053,215.25	559,684,032.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,000.00	152,171,132.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,000.00	152,171,132.00
1200017	Үнэ төлбөргүй орлого /ҮХ	00.00	152,171,132.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	291,032,215.25	407,512,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	267,273,800.00	363,395,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		363,395,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	267,273,800.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,789,530.00	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,789,530.00	500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,968,885.25	43,617,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,968,885.25	43,617,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	296,817,274.34	363,172,236.51

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	296,817,274.34	363,172,236.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	283,808,139.34	358,810,404.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,359,006.00	234,124,558.39
210101	Үндсэн цалин	166,131,449.00	179,646,006.26
210102	Нэмэгдэл	19,019,065.00	37,957,960.13
210104	Урамшуулал	00.00	4,075,936.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,208,492.00	12,444,656.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,757,320.69	30,415,552.74
210201	Тэтгэврийн даатгал	24,757,320.69	21,675,042.57
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	2,588,556.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,958,483.26
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	360,243.62
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,833,226.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,606,085.25	24,348,243.29
210301	Гэрэл, цахилгаан	1,085,765.25	2,468,743.29
210302	Түлш, халаалт	17,026,020.00	20,988,500.00
210303	Цэвэр, бохир ус	494,300.00	891,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,631,160.40	305,750.00
210401	Бичиг хэрэг	800,010.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,454,850.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	885,630.00	200,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	342,900.00	105,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,933,770.40	00.00
210408	Бараа материал акталсны зардал	214,000.00	00.00
2105	Нормативт зардал	12,205,546.00	34,975,695.00
210502	Хоол, хүнс	12,205,546.00	34,975,695.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,125,110.00	1,572,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	603,500.00	500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	171,610.00	1,072,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,123,911.00	33,068,405.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,076,900.00	9,341,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,971,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,047,011.00	20,755,555.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,009,135.00	4,361,831.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,789,530.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,789,530.00	00.00

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	4,361,831.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,361,831.71
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,219,605.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,219,605.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-5,764,059.09	196,511,795.49
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	210,373.33	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	210,373.33	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-210,373.33	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-5,974,432.42	196,511,795.49

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	291,053,215.25	407,512,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	291,032,215.25	407,512,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	267,273,800.00	363,395,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	363,395,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	267,273,800.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,789,530.00	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,789,530.00	500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,968,885.25	43,617,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,968,885.25	43,617,000.00

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	282,232,415.25	345,535,418.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	282,232,415.25	345,535,418.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	269,223,280.25	341,173,586.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,963,504.00	238,813,355.39
210101	Үндсэн цалин	139,361,393.00	183,488,988.26
210102	Нэмэгдэл	22,942,514.00	38,923,180.13
210104	Урамшуулал	27,561,880.00	3,356,531.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,097,717.00	13,044,656.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,165,236.00	30,415,552.74
210201	Тэтгэврийн даатгал	17,643,446.00	19,981,610.46
210202	Тэтгэмжийн даатгал	1,401,651.00	2,559,600.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,104,680.00	1,987,439.66
210204	Ажилгүйдлийн даатгал	274,323.00	491,622.67
210205	Эрүүл мэндийн даатгал	2,741,136.00	5,395,279.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,968,885.25	23,923,243.29
210301	Гэрэл, цахилгаан	1,085,765.25	2,468,743.29
210302	Түлш, халаалт	18,388,820.00	20,563,500.00
210303	Цэвэр, бохир ус	494,300.00	891,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,388,184.00	105,000.00
210401	Бичиг хэрэг	1,589,010.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,735,550.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,357,240.00	00.00
210404	Ном, хэвлэл	310,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	165,000.00	105,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,230,884.00	00.00
2105	Нормативт зардал	16,169,471.00	33,104,685.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	335,000.00	00.00
210502	Хоол, хүнс	14,914,471.00	33,104,685.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	920,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,039,200.00	370,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,310,000.00	00.00
210602	Тавилга	659,200.00	00.00
210604	Урсгал засвар	2,070,000.00	370,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,257,000.00	1,442,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	667,000.00	500,000.00

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	942,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,271,800.00	12,999,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,941,800.00	9,538,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	330,000.00	3,460,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,009,135.00	4,361,831.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,789,530.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,789,530.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	4,361,831.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,361,831.71
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,219,605.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,219,605.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,820,800.00	61,977,481.87
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,820,800.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,820,800.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,820,800.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,820,800.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-8,820,800.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	61,977,481.87
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	61,977,481.87

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	100,436,916.11	896,802,758.42	-16,894,732.40	980,344,942.13
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	100,436,916.11	896,802,758.42	-16,894,732.40	980,344,942.13
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	100,436,916.11	896,802,758.42	-16,894,732.40	980,344,942.13
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	196,511,795.49	196,511,795.49
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	100,436,916.11	896,802,758.42	179,617,063.09	1,176,856,737.62

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	407,012,900.00	340,673,586.42	66,339,313.58	83.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	407,012,900.00	340,673,586.42	66,339,313.58	83.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	362,460,400.00	327,598,236.42	34,862,163.58	90.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	292,827,400.00	238,792,355.39	54,035,044.61	81.55
210101	Үндсэн цалин	225,910,800.00	183,024,786.26	42,886,013.74	81.02
210102	Нэмэгдэл	47,311,600.00	37,957,990.13	9,353,609.87	80.23
210104	Урамшуулал	3,194,000.00	4,321,751.00	-1,127,751.00	135.3
210105	Гэрээт ажлын хөлс	16,411,000.00	13,487,828.00	2,923,172.00	82.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,603,500.00	30,415,552.74	6,187,947.26	83.09
210201	Тэтгэврийн даатгал	24,890,300.00	19,981,610.46	4,908,689.54	80.28
210202	Тэтгэмжийн даатгал	2,928,400.00	2,559,600.33	368,799.67	87.41

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,342,600.00	1,987,439.66	355,160.34	84.84
210204	Ажилгүйдлийн даатгал	585,700.00	491,622.67	94,077.33	83.94
210205	Эрүүл мэндийн даатгал	5,856,500.00	5,395,279.62	461,220.38	92.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,434,600.00	23,923,243.29	511,356.71	97.91
210301	Гэрэл, цахилгаан	2,871,100.00	2,468,743.29	402,356.71	85.99
210302	Түлш, халаалт	20,563,500.00	20,563,500.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	891,000.00	109,000.00	89.10
2104	Хангамж, бараа материалын зардал	220,000.00	105,000.00	115,000.00	47.73
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	220,000.00	105,000.00	115,000.00	47.73
2105	Нормативт зардал	38,166,200.00	33,049,685.00	5,116,515.00	86.59
210502	Хоол, хүнс	38,166,200.00	33,049,685.00	5,116,515.00	86.59
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	370,000.00	130,000.00	74.00
210604	Урсгал засвар	500,000.00	370,000.00	130,000.00	74.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	962,000.00	942,400.00	19,600.00	97.96
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,000.00	942,400.00	19,600.00	97.96
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13299200.00	13075350.00	223,850.00	98.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,789,200.00	9,614,550.00	174,650.00	98.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,510,000.00	3,460,800.00	49,200.00	98.60
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	407,012,900.00	402,651,068.29	4,361,831.71	98.93
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	363,395,900.00	363,395,900.00	0.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	363,395,900.00	363,395,900.00	0.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	43,617,000.00	39,255,168.29	4,361,831.71	90.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	00.00	00.00	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13.00	13.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	0.00	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн зорилго, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд зааснаар “бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж зорилго зорилтыг тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар :

- Засгийн газрын 2021.12.21-ны 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар байгуулагдсан
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан хувьсах зардлын дундаж норматив, аргачлал
- БШУ-ны сайдын 2022 оны “Заавар батлах тухай “ А/170 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх заавар аргачлал “
- БШУ-ны сайд, ЭМС-ын 2022 оны А/235, А/340 дугаар хамтарсан “Багшийн эрүүл мэндийн талаар авах арга хэмжээний тухай тушаал
- Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2022 оны 107, 192 дугаар тогтоолууд
- БШУ-ны сайдын 2022 оны А/430 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх дүгнэх журам,
- БШУ-ны сайдын 2022 оны А/500 тоот тушаалаар батлагдсан Гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулал олгох журам

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Харин Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д зааснаар Цэцэрлэгийн хувьсах зардлаар тооцсон зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаатай холбоотой 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайланг БШУЯ-ны Боловсролын ерөнхий газарт нэгтгэгдэж, орон нутгийн ТЭЗ-ын санхүүгийн тайланд нэгтгэгдээгүй, Сангийн яамны Э-тайланд хөрөнгө шилжүүлэн тайланг гаргаж, орон нутгийн тайлан эхний үлдэгдэлтэй эцсийн үлдэгдэлгүй, Улсын төсвийн тайланд эцсийн үлдэгдлээр тайланг нэгтгэсэн байна.

Дотоод хяналтыг ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баянхонгор аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс 2021 онд боловсруулсан, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,177,397.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 195,793.0 мянган төгрөгөөр буюу 19.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	69,928.2	136,065.3	66,137.1
Мөнгөн хөрөнгө	-	61,977.5	61,977.5
Авлага	560.5	560.5	-
Урьдчилгаа	100.0	4,070.0	3,970.0
Бараа материал	69,267.7	69,457.3	189.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	911,675.9	1,041,331.8	129,655.9
Үндсэн хөрөнгө	1,039,673.0	1,190,084.5	150,411.5
Хуримтлагдсан элэгдэл	(127,997.1)	(148,752.7)	(20,755.6)
Нийт хөрөнгө	981,604.1	1,177,397.1	195,793.0

Өр төлбөр	1,259.1	540.4	(718.8)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	980,344.9	1,176,856.7	196,511.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	981,604.1	1,177,397.1	195,793.0

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 61,977.5 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 4,070.0 мянган төгрөг болж 3,970.0 мянган төгрөгөөр өссөн нь ажилтнуудад олгосон урьдчилгаа цалинг бүрэн суутгаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 69,457.3 мянган төгрөг болж 189.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд нийт 42,758.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 1,769.7 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авснаар бүртгэж, 44,328.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан үзүүлэлттэй байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,190,084.5 мянган төгрөг болж 150,411.5 мянган төгрөгөөр өссөн нь БШУ-ны сайдын 2022.11.23-ны “Журам батлах тухай” А/488 дугаар тушаалаар батлагдсан “Боловсролын салбарын мэдээллийн систем ашиглах, мэдээллийн сан бүрдүүлэх, зохицуулах журам”-ын хүрээнд Боловсролын ерөнхий газраас 2,273.8 мянган төгрөгийн үнэтэй 2ш зөөврийн компьютер, аймгийн БШУГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, "Шимт боловсрол" ХХК-ийн захирал, Эрдэнэцогт сумын цэцэрлэгийн эрхлэгч нарын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээгээр 3,410.0 мянган төгрөгөөр тавилга, эд хогшил нийлүүлэгдсэн, аймгийн ЗДТГ-ын 2023.01.12-ны 5/86 дугаар бүхий албан бичгийг үндэслэн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн цэцэрлэгийн барилгын их засварын ажлын 142,453.4 мянган төгрөгийн ажлыг барилга байгууламжийн сайжруулалтаар бүртгэсэн нь нөлөөлжээ.

Өглөг дансны үлдэгдэл 718.8 мянган төгрөгөөр буурсан боловч өмнөх оны үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,176,856.7 мянган төгрөг болж 196,511.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант хугацаанд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын санхүүжилтээр бүрэн санхүүжүүлэхээр тооцон 651,500.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн саналыг бууруулан 321,756.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативаар тооцож төсвийг хуваарилсан, төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарахад болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжийн зардал, боловсролын байгууллагуудын ажилтнуудад улирал тутам олгодог үр дүнгийн урамшуулал олгох хэлбэр зэрэгт өөрчлөлт орсонтой холбоотой байна.

Тайлант хугацаанд тус цэцэрлэгийн төсвийн хуваарьт 2022 оны 12 дугаар сард өөрчлөлт орж, улсын төсвөөс авах санхүүжилтийг 363,395.9 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 43,617.0 мянган төгрөгөөр буюу нийт зарлагыг 407,012.9 мянган төгрөгөөр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхэд 407,012.9 төгрөгийн төсөв батлагдсаныг бүрэн авч зарцуулсан байна.

Тайлант оны батлагдсан төсөвт 2 удаа өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 340,673.6 төгрөг буюу 83.7 хувьтай байгаа нь тогтмол зардлын санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдлийн 4,361.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, улсын төсвөөс олгосон санхүүжилтээс 61,977.5 мянган төгрөгийг зарцуулаагүй, мөнгөн хөрөнгө дансанд үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт
ХӨТӨЛБӨР 71801- Сургуулийн өмнөх боловсрол	407,012.9	340,673.6	66,339.6	83.7
АРГА ХЭМЖЭЭ 80112 –Нийтлэг үйлчилгээ	43,617.0	39,255.2	4,361.8	90.0
АРГА ХЭМЖЭЭ 81605- Эрүүл мэндийг дэмжих	1,300.0	1,285.0	15.0	98.0
АРГА ХЭМЖЭЭ 81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	38,166.2	33,049.7	5,116.5	87.0
АРГА ХЭМЖЭЭ 81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,909.2	1,909.0	0.2	100
АРГА ХЭМЖЭЭ 81823- Боловсролын байгууллагын багш,	1,300.0	1,210.0	90.0	93.0
АРГА ХЭМЖЭЭ 81834- Боловсролын стандарт, сургалт	285,985.5	234,019.5	51,966.0	82.1

АРГА ХЭМЖЭЭ 81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	34,735.0	29,945.2	4,789.8	84.7
---	----------	----------	---------	------

Эх сурвалж: 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Глобал капитал аудит” ХХК-нийн аудитор Д.Энхтуяа, Д.Цэцэгмаа нар 2023 оны 1 дүгээр сарын 25-наас эхлэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар хэрэгжүүлсэн.

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 67 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсөвт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг завсрын аудит хийх явцад анхны батлагдсан төсөвт зардлын 279,909.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,123.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг

байдлын 75.0%-иар тооцон 3,092.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилтийн хүрээнд 407,012.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас батлагдсан төсвөөс нийт 66,339.3 мянган төгрөгийг хэмнэснээс хуульд хамаарах доорх зардлыг хэмнэсэн байна. Үүнд:

- Тогтмол зардлыг 4,361.8 мянган төгрөгөөр
- Хүүхдийн хоолны зардлыг 5,116.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаатай холбоотой 38,166.2 мянган төгрөгийн 3 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 351,377.8 мянган төгрөгийн 23 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 33,104.7 мянган төгрөгийн 6 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 12,027.8 мянган төгрөгийн 8 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийсэн ба завсрын аудитаар зөрчил, дутагдал илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 12,782.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 9,741.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, 3,040.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан тухай тайланг 2022.11.04-ний өдрийн 29 дугаар албан бичгээр БНА-2023/92/НА-СТА-ТШЗ

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж, Fas программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	9,741.9	1	9,741.9	100
Албан шаардлага	1	3,040.6	1	3,40.6	100
Нийт дүн	2	12,782.5	2	12,782.5	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Засгийн газрын "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 2019 оны 450 дугаар тогтоолын 4-т " Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байхыг БСУШУС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 онд хоолны зардал 5,116.5 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

- Ажилтнуудад их хэмжэний цалингийн урьдчилгаа цалин олгоод суутган тооцоогүй,ажилтнуудын цалингийн санг НДХ-т дутуу мэдээлдэг зөрчил дутагдал давтагдан гарсаар байгаад байгууллагын удирдлагын зүгээс тавих хяналтыг сайжруулах шаардлагатай.

5.Аудитын илрүүлэлт

Аудитаар 548.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч¹ аудитын явцад залруулав. Үүнд:

5.1. Залруулга

1. Ажилтнуудын цалингаас суутгаад төлөөгүй ХХОАТ-ын өглөгийг 226.7 мянган төгрөгөөр, хамтын сангийн өглөгийг 260.0 мянган төгрөгөөр дутуу, ҮЭ-ийн татварыг 61.6 мянган төгрөгөөр илүү төлөөд авлагаар бүртгээгүй байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Зөрүүтэй тусгасан өглөг авлагын 548.3 мянган төгрөгийг санхүүгийн тайланд залруулах

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар 12,688.4 мянган төгрөгийн зөрчил илэрч², 4,370.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 8,318.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгөв.

5.2. Төлбөрийн акт

1. Цалингийн зардлыг анхан шатны баримтаас хөөн тулган шалгахад ажилтнуудад олгосон урьдчилгаа цалингийн авлага 4,370,000 төгрөгийг дутуу суутгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Санхүүгийн тайлагналын “Үнэлгээ ба хуваарилалт”, гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудад олгосон цалингийн урьдчилгааны 4,370.0 мянган төгрөгийг хавсралтад дурдсан ажилтнуудаас суутган тооцож төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.3. Албан шаардлага

1.Ажилтнуудад олгосон цалингийн урьдчилгаанаас 1 ажилтнаас 400.0 мянган төгрөгийг илүү суутгаад санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү суутгасан урьдчилгаа цалингийн 400.0 мянган төгрөгийг буцаан олгуулахаар албан шаардлага өгөв

2. Аймгийн НДХ-т ажилтнуудын 2022 оны 12-р сарын цалинг 7,918.8 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст дутуу мэдээлсэн ажилчдын 2022 оны 7,918.8 мянган төгрөгийн цалингийн санг нөхөн мэдээлж зөрчлийг арилгах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Ажилтнуудын цалингаас суутгаад төлөөгүй ХХОАТ-ын өглөгийг 226728 төгрөгөөр, хамтын сангийн өглөгийг 260.0 мянган төгрөгөөр дутуу, ҮЭ-ийн татварыг 61591 төгрөгөөр илүү төлөөд авлагаар бүртгээгүй байна	1	548.3			1	548.3	1	548.3						
	1	548.3			1	548.3	1	548.3						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн		
Цалингийн зардлыг анхан шатны баримтаас хөөн тулган шалгахад ажилтнуудад олгосон урьдчилгаа цалингийн авлага 4370.0 мянган төгрөг байхад 3970.0 мянган төгрөгөөр буюу авлагыг 400.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан	1	4,370.0	1	4,370.0										
Ажилтнуудад олгосон цалингийн урьдчилгаанаас 1 ажилтнаас 400.0 мянган төгрөгийг илүү суутгаад санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй байна.	1	400.0			1	400.0								
НДХ-т ажилтнуудын 2022 оны 12-р сарын цалинг 6,564.9 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн	1	7,918.8			1	7,918.8								
ДҮН	3	12,688.8	1	4,370.0	2	8,318.8								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар

30/4425182

Номгон

БНА-2023/92/НА-СТА-7MB

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлыг анхан шатны баримтаас хөөн тулган шалгахад ажилтнуудад олгосон урьдчилгаа цалингийн авлага 4,370,000 төгрөгийг дутуу суутгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэснийг зөрчсөн .

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5.бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Урьдчилгаа цалингийн 4,370,000 /Дөрвөн сая гурван зуун далан мянган/ төгрөгийг хавсралтад дурдсан ажилтнуудаар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх¹

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн эрхлэгч Ж.Содномчимэг, нягтлан бодогч Ж.Оюунтуяа нарт хариуцуулав².

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Д.ЦЭЦЭГМАА

6417143544
БЮА0067 9007423

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

005050088

Д.Д	Ажилтны нэрс	Олгосон урьдчилгаа /Сараар /										Сутгал / сараар /				ДҮН		Дугуу	Илүү		
		1	2	4	6	7	8	9	10	5	6	7	8	9	10	11	12				
1	Анхцэцэг	800,000				750,000				1,560,000								1280000	1480000	70,000	
2	Батцэрэн	800,000				500,000				1,300,000								500000	1300000	-	
3	Ундрах	500,000								900,000									900000	-	400000
4	Оюунчимэг	400000	500000							900,000								200000	1450000		
5	Сарангуа	800000								2,000,000								400000	1200000	500,000	
6	Нарантуяа	800000								2,800,000								1,000,000	1800000	1,000,000	
7	Мөнхсавтар	100000			450000					550,000								200000	500000	1,450,000	
8	Өлзийсайхан	500000								1,100,000								200000	500000	-	
9	Оюунтуяа		500000			300000				1,100,000								150000	150000	950,000	
10	Оюунчимэг						300000			750,000								200000	200000	-	
11	Хажидсүрэн			500000						500,000								100000	500000	-	
12	Нансал			1000000						2,000,000									1000000	1,000,000	
13	Содномчимэг					700000				1,700,000								1700000	1700000	-	
14	Ганчимэг									1,000,000								200000	1000000	-	
15	Баярагч									400,000									0	400,000	
16	Мөнххуран									700,000								700000	700000	-	
	ДҮН	4,700,000	1,000,000	1,500,000	1,150,000	6,450,000	1,050,000	1,400,000	700,000	17,950,000							27000000	13980000	4,370,000	400000	

Handwritten notes in red ink:

- 1000000
- 1000000
- 1000000
- 1000000
- 1000000



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар

21/14425182
БНА-2023/92/НА-СТА-ТШЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 12 дугаар сард Нийгмийн даатгалын хэлтэст ажилтнуудын цалингийн санг 7,918,764 төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нийгмийн даатгалын хэлтэст дутуу мэдээлсэн 7,918,764 /Долоон сая есөн зуун арван найман мянган долоон зуун жаран дөрвөн / төгрөгийн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн эрхлэгч Ж.Содномчимэг, нягтлан бодогч Ж.Оюунтуяа нарт даалгав²

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР Д.ЦЭЦЭГМАА

6417143544
БНА0067 0007423

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

21/АО14425182 тоот
албан шаардлагын
хавсралт

№	Овог	Нэр	Олговол зохих цалин	НДШ	Зөрүү
1	Баасанбат	Бямба	915958	523405	392553
2	Жаргалсайхан	Оюунчимэг	1603193	1072659	530534
3	Багмид	Батсүрэн	1956606	1690722	265884
4	Гончигдагва	Ганчимэг	2077207	1798029	279178
5	Даваа	Дамдинжав	1488952	1223068	265884
6	Машгиа	Доржханд	1310045	626544	683501
7	Зөмүү	Мөнхбаатар	1046810	575746	471064
8	Жадамбаа	Содномчимэг	2252397	1576678	675719
9	Жаргалсайхан	Оюунтуяа	701954	319070	382884
10	Энх-амгалан	Солонго	1081622	845247	236375
11	Дашдаваа	Хажидсүрэн	1450666	995922	454744
12	Баасанбат	Эрдэнэдаваа	1053733	569585	484148
13	Банзрагч	Анхцэцэг	1609589	1079055	530534
14	Мөнхөө	Өлзийсайхан	1046810	575746	471064
15	Ганзориг	Гомбосүрэн	994469	523405	471064
16	Бямба	Мөнхуран	1174915	1127525	47390
17	Аюурзана	Нарантуяа	2422773	1784651	638122
18	Сосорбарам	Оюунцэцэг	1431390	1431390	0
19	Сангидорж	Сарангуа	2031440	1393318	638122
		Нийт : 19	27650529	19731765	7918764



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 22/74425132
БНА-2023/92/НА-СТА-ТУЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилтнуудад олгосон цалингийн урьдчилгаанаас 1 ажилтнаас 400,000 төгрөгийг илүү суутгаад санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Урьдчилгаа цалинг илүү суутгаад өглөгөөр бүртгээгүй 400,000 /Дөрвөн зуун мянган/ төгрөгийг ажилтан н.Ундрахад буцаан олгож, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Цэцэрлэгийн эрхлэгч Ж.Содномчимэг, нягтлан бодогч Ж.Оюунтуяа нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³.

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ
"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Д.ЦЭЦЭГМАА

6447143544
6470067 9007423

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно